



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/04

Аргатай

Хорио цээрийн дэглэм
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.9, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоол, Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 23-1504, 23-1505 бүртгэлийн дугаартай шинжилгээний дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын Аргатай 3 дугаар багийн нутаг дэвсгэрт бог малын гоц халдварт мялзан өвчний голомт үүссэн тул 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс голомтоос 15 километрийн радиуст 21 хоногийн хугацаатайгаар хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Бог малын гоц халдварт мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг сумын онцгой комиссын шуурхай штабын дарга (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Хорио цээрийн бүсийн хүн амын хөдөлгөөнд хяналт тавьж хэв журам сахиулж ажиллахыг Хэсгийн цагдаа (Б.Далхсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Хорио цээрийн бүсэд хийгдэх халдваргүйтгэл, малын эрүүл мэндийн үзлэгийг чанартай хийж, цааш дэлгэрүүлэхгүй байх ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГ  Б.ЗОЛЗАЯА



This PC/local disk(D)2023он/эз-н актууд/захирамж 2023

482301014

Боловсруулсан: *У. Хатбуца*
Хянасан: *Н. Зоуза*
Хувь: *2%*